



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/106

Бат-Өлзий сум

Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ой бүхий 1000 га талбайд “Гранд Форест” хязгаарлагдмал хариуцлагатай компани ойн хортон шавж устгалын ажлыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан 3 дугаар багийн Өвтийн хошуунаас дээш Могойт, Мойлт, Бугат, Хамар, Төмөрт, Хүүхдийн асга, Хөнөг, Мөст, Мухдаг, Билүүт гэх газруудад 2022 оны 06 дугаар сарын 21-нээс 2022 оны 07 дугаар сарын 04 хүртэлх хугацаанд хорио цээр тогтоосугай.

2. Хорио цээр тогтоосон газарт мал оруулахгүй байхыг малчин, мал бүхий иргэдэд сурталчлан ажиллахыг Багийн Засаг дарга (С.Төмөр, Д.Бямбасүрэн, Ж.Нямтогтох, Л.Балжинням) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Ж.Батмөнх, Б.Энхмаа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

